

УЛС ТӨР

**АЖ АХУЙН НЭГЖИЙН
ТАТВАРЫН ДАРАМТ БУУРАХ НЬ**

II нүүрт

SPEAK OUT

**ЗАСГИЙН ГАЗРЫН 100 ХОНОГТ
АМЖУУЛСАН АЖИЛД ИРГЭД “Г”
ДҮН ТАВИВ**

V нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Дугаарын **60** мөр

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

Хүүхэд рүү “хүрз
далайх” чинь
ариун явдал уу

Ж.ОТГОН

Ямар ч эх, эцэг өөрөө нүцгэн гүйж, хоосон хонож байгаад ч хамаагүй үр хүүхэддээ хамаг бүхнээ зориулдаг. Өөрөөр хэлбэл, манай гэрийн санхүү хүнд байна гээд л хамгийн түрүүнд хүүхэддээ зарцуулах мөнгөнөөсөө хасаад, өөртөө зарцуулаад сууж байдаг хүн байхгүй. Гэтэл шинэ Засгийн газар үүнийг яг эсрэгээр нь хийж “хойд эх”-ийн санаа гаргаж байна. Ер нь хойд эх ч үрчилж авсан үр хүүхэддээ сайн сайхныг хүсдэг болохоос энэ Засгийн газар шиг ингээд “шийтгээд” байдаггүй байх.

Улс орны эдийн засаг хүнд байна гэсэн шалтга хэлээд хасалт, таналтаа хамгийн түрүүнд хүүхдийн мөнгө, хөгжлийн тэтгэврээс эхлүүлчихлээ.

Үргэлжлэл нь III нүүрт

ТОЛГОЙТЫНХОН ДАРАА ЖИЛ ХҮРТЭЛ

ШИНЭ ЗАМ ДЭЭР ГИШГЭХГҮЙ НЬ...



Н.БАТЗАЯА

Сонгуулийн өмнөхөн Орбитын уулзвараас Толгойтын эцэс хүртэлх замыг өргөтгөн

шинэчилж, төмөр бетонон гүүр барих нэрийдлээр тус чиглэлийн автобусны чиглэлийг хүртэл өөрчилж, сур дулиантай эхэлсэн замын барилгын ажил зогсчихлоо

хэмээн Толгойтын оршин суугчид бухимдах болов. Автобусны чиглэл өөрчлөгдсөний улмаас иргэд 2-3 км гаруй газарт алхаж хөл дүүжлэх унаатай залгах болжээ. Яагаад

сонгуулийн өмнөхөн хөрөнгө, санхүүжилт нь шийдэгдсэн зам барилгын ажил удааширч, царцсан ажлын тоог нэмэх болов гэдэг иргэдийн дунд асуулгын тэмдэг хэвээр байна. Тиймээс бид Орбитын уулзвараас Толгойтын эцэс хүртэлх зам барилгын ажлыг хөндөн энэ удаагийн “Дугаарын сурвалжлага”-аа бэлтгэлээ.

Толгойтын замын ажил зогсоогүй

Толгойтын замыг шинэчлэх асуудал олон жил яригдаж үлгэр домог болсон гэхэд болно. Нэг хэсэг хөрөнгө санхүүжилт нь шийдэгдэхгүй байна гэх шалтгаар хэдэн жилээр ухарч байсан удаатай. Харин төсөв мөнгө нь шийдэгдсэний дараа барилгын ажил гүйцэтгэх компани олдохгүй байна гэж шалтаг тооцсон ч уг ажлыг хийх компани нэг юм олдож, сонгуулийн өмнө барилгын ажлаа суржин эхэлсэн.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛБАНК ЮУ ХИЙГЭЭД БАЙНА АА

Н.ПУНЦАГБОЛД

Яг ийм асуулт сүүлийн үед урган гарч ирээд байгаа. Төв банкны тухай хуульд Төв банкны үйл ажиллагаа нь Засгийн газраас хараат бус байхаар заасан. Энэ бол олон улсын жишигт нийцсэн чухал дэвшилтэт заалт. Нөгөөтэйгүүр дэлхий нийтийн хандлага Төв банкаа аль болох илүү эрх мэдэлтэй, хараат бус байлгахад чиглэж байгаа. Манайх энэ чигийг барьж, Төв банкны тухай хуульдаа Засгийн газраас хараат байх ёстой гэж хуульчилж өгсөн. Харамсалтай нь энэ хуулийн заалтаа нэг л дагахгүй байх шиг. Өмнө жилүүдэд Монголбанк хараат бус байж чадаагүйг олон баримт харуулдаг. Харин 2016 оны сонгуулийн үр дүнд МАН үнэмлэхүй ялалт байгуулж, Засгийн газраа

эмхлэн байгуулсан. Улмаар Монголбанкны Ерөнхийлөгчийг сольж, Н.Баяртсайханыг томилсон билээ. Энэ хүнийг Монголбанкны Ерөнхийлөгч болсноос хойш хийж буй ажил, баримталж байгаа байр суурийг нь хараад, хараат бус ажиллаж чадах юм байна гэсэн итгэл төрж байв. Ипотекийн таван хувийн зээлийг хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг шуудхан хэлсэн. Засгийн газар ипотекийн зээлд хамрагдах орон сууцны ам.метрийн хязгаарыг нэмэгдүүлэх шийдвэр гаргах гэж байхад хүртэл Төв банкнаас санхүүжүүлэх боломжгүй гэдгээ мэдэгдэж байсан. Хэрвээ ийм шийдвэр гаргавал Засгийн газар өөрсдөө санхүүгийн эх үүсвэрээ зохицуулж, шийдвэрлээрэй гэж байв.

Үргэлжлэл нь III нүүрт

МЭНДЧИЛТЭЭ



Эрхэм хүндэт багш, сурган хүмүүжүүлэгч, гэдний мянга мянган шавь нар, Монголын боловсролын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан бидэнтэй хамтран ажиллаж байгаа дотоод, гадаадын байгууллага, боловсролыг эрхэмлэгч нийт иргэд ээ!

Та бүхэнд Дэлхийн болон Монголын багш нарын өдрийг тохиолдуулан чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны нэрийн өмнөөс болон хувиасаа ажил хөдөлмөрийн амжилт, амьдралын сайн сайхан бүхнийг хүсэн мэндчилье.

Монголын үе үеийн багш нар нийгмийн өмнө хүлээсэн мэргэжлийн үүргээ нэр төртэй биелүүлж, хүн ардаа соён гэгээрүүлэх үйлсдээ үнэнчээр зүтгэн, хөдөөгийн уул талаар соёлын үрнийг тарьж, ард түмнээ хөгжлийн замд хөтөлсөөр ирсэн билээ.

Монголчууд бид “Багш дор мөргөө. Ном дор мөргөө” хэмээн багшийг шүтэн дээдэлж ирсэн сайхан уламжлалтай ард түмэн. Багшаар эрдэм заалгаагүй хүмүүн гэж үндсэндээ байхгүй бөгөөд хүн бүр “БАГШ АА” гэж суу алдрыг нь дуурсан эрхэмлэн хүндэтгэж явдаг. Тиймээс энэ өдөр эрдмийг эрхэмлэдэг, багшийнхаа ач тусыг санаж явдаг хүн бүрийн баяр юм.

Багш нар олны тусын тулд ирээдүйн үйл хэргийн төлөө бахдам үйл бүтээж яваа хөтөч төдийгүй бусдыг гэрэлтүүлэхийн төлөө

өөрийгөө зориулдаг гавьяатан болохыг энэ өдөр бахархан хэлэхэд таатай байна.

Нийгмийн үндсэн баялаг болох хүний хөгжил багш Таны итгэл, сэтгэл, зүтгэл шингэсэн их хөдөлмөрийн үр дүн билээ. Та бүхний минь сургаж, хүмүүжүүлсэн шавь нар Монгол Улсаа хөгжүүлэх үйл хэргийг бүтээн байгуулагч, удирдан чиглүүлэгч төдийгүй эх орноо тив дэлхийд алдаршуулсан, бүтээлч хөдөлмөрөөрөө монгол хүний суу билэг, сэтгэлийн хат, оюуны чадавхийн гайхамшигийг мэдрүүлж чадсан гавьяа ч үе үеийн багш нарынх.

Эрхэм хүндэт багш, сурган хүмүүжүүлэгчид ээ!

Монгол Улсын Засгийн газраас боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар, багшийг хүний хөгжлийн тулгуур хүч гэж үзэж, багш, албан хаагчдын хөгжил, нийгмийн асуудалд онцгой анхаарал хандуулж ирсэн бөгөөд цаашид ч бодлого, үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэл, зорилт болгосор байх болно.

Шинэ зууны хөгжлийн түүхийг бүтээлцэх, боловсролын шинэчлэлийн түүхээ болсон Багш нартаа дахин баяр хүргэж, Та бүхний алдар суу, амжилт бүтээл өөдрөг байхыг ерөөе.

Нотын цагаан буян дэлгэрч, эрдэм оюуны эх булаг ундран арвижих болтугай!

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД **Ж.БАТСУУРЬ**

ХААН Банк					Хугалгаа хөгжлийн банк						
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах			
АМ.ДОЛЛАР	2282.00	2295.00	ФУНТ	2886.00	2984.00	АМ.ДОЛЛАР	2282.00	2293.00	ФУНТ	2884.00	2956.00
ЕВРО	2531.00	2597.00	РУБЛЬ	35.20	38.20	ЕВРО	2523.00	2587.00	РУБЛЬ	35.35	38.42
ИЕН	22.16	22.74	ЮАНЬ	341.00	344.40	ИЕН	22.00	22.63	ЮАНЬ	340.50	343.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Унгарын Засгийн газрын тэтгэлгээр жил бүр 200 оюутан суралцана

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Унгар улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Акомш Мадаринг хүлээн авч уулзлаа. Монгол Улс өөрийн гуравдагч хөрш, Европын Холбооны гишүүн Унгар улстай харилцах харилцаанд өндөр ач холбогдол өгдөг. Хамтын ажиллагааг шинэ агуулгаар баяжуулж, эдийн засаг, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт өргөжүүлэн хөгжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа Ерөнхий сайд илэрхийллээ. Унгар улс Элчин сайдын яамаа сэргээн нэвсгээр хоёр талын улс төрийн харилцааг бэхжүүлэх, бусад салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгааг Ерөнхий сайд онцолсон юм. Биокорбинат ТӨҮГ-ыг Унгарын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр бүрэн шинэчилснээр хоёр улсын хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагаа өргөжих төдийгүй энэ төсөл нь хоёр улсын харилцааны билэг тэмдэг болохыг дурьдлаа. Хоёр орны эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг нийтлэг зорилтын хүрээнд Европын стандартад нийцсэн хамтарсан үйлдвэр байгуулах, бүтээгдэхүүнээ ОХУ, БНХАУ-ын зах зээлд нийлүүлэх боломж байгааг мөн онцоллоо. Унгарын Засгийн газрын тэтгэлгээр тус улсад жил бүр 100 монгол оюутан суралцаж буй. Оюутны тоог нэмж, 2017 оноос жил бүр 200 оюутан сургахаар болсон гэдгийг Унгар улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Акомш Мадари хэллээ.

БАЙНГЫН ХОРОО

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТАТВАРЫН ДАРАМТ БУУРАХ НЬ

Ж.МЯГМАР

УИХ-ын Төсвийн болон Хууль зүйн байнгын хороод хуралдлаа. Харин Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны хуралдаан өчигдөр болох байсан ч цуцлагдлаа. УИХ-ын гишүүдийн ирц бүрдэхгүйгээс дэд хорооны хуралдаан хойшилсон юм. Уг хуралдаанаар Тогтвортой хөгжлийн зорилго, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 зэрэг хөтөлбөр мэдээлэл сонсох байсан юм. Эхний мэдээллийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс, хоёр дахийг нь Үндэсний хөгжлийн газраас хийх байв.

Ж.Батзандан: Татварын хөнгөлөлтөд дөрөвхөн салбарыг онцлон оруулсан нь өрөөсгөл байна

УИХ-ын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэлээ. Засгийн газраас өргөн мэдүүлсэн уг хуулийн төслийн талаар хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн дэд сайд Х.Булгантуяа танилцуулсан юм. Өнгөрсөн жилүүдэд манай улсын эдийн засгийн өсөлт удааширч, ажилгүйдлийн төвшин нэмэгдэх хандлагатай байгаа. Иймээс бизнесийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, хөрөнгө оруулалтыг татах илүү таатай эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байгааг дэд сайд онцолж байлаа. Монгол Улсын нийт аж ахуйн нэгжүүдийн дийлэнх хувь нь жижиг, дунд бизнес эрхлэгчид байдаг. Иймээс жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, тэдний татварын ачааллыг багасгаж, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагаагаа тэлэх боломжийг олгосноор эдийн засгийн өсөлтийг хурдасгах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой гэж үзэж байгаа. Тиймээс ч Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

боловсруулсан аж. Уг хуулийн төсөлд жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй, хүнсний үйлдвэрлэл, хувцас, нэхмэлийн үйлдвэрлэл, барилгын материалын болон газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн үндсэн үйл ажиллагааны орлогод 2017 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны нэгдүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нэг хувиар орлогын албан татвар ногдуулахаар буюу ногдуулсан татварыг 90 хувиар хөнгөлөхөөр тусгасан байна. Ийнхүү жижиг дунд буюу жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй аж ахуйн нэгжид нэг хувиар албан татвар ногдуулах зохицуулалтыг хийснээр аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа задлах, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх замаар энэхүү хөнгөлөлтөд өргөнөөр хамрагдах хэдий ч улмаар төсвийн орлогын эх үүсвэрт сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл байгаа. Иймээс албан татвар төлөгчийн тайлант жилийн албан татвар ногдох орлогыг тодорхойлохдоо тухайн албан татвар төлөгч болон түүнтэй харилцан хамаарал бүхий этгээдийн албан татвар ногдох орлогын нийлбэр дүнгээр тодорхойлохоор хуулийн төсөлд тусгасан байна.

Хэлэлцүүлгийн шатанд УИХ-ын гишүүн Ж.Батзандан жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй аж ахуйн нэгжид нэг хувиар

...УИХ-ын гишүүн Ч.Улаан, Ц.Даваасүрэн нар уг хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа, гэхдээ ирэх оны төсөвтэй уялдуулж ярилцах шаардлагатай гэсэн байр суурийг илэрхийллээ...

албан татвар ногдуулахдаа дөрөвхөн салбарыг онцолсныг өрөөсгөл бөгөөд бусад салбарыг ч хамруулахаар судлах хэрэгтэйг сануулж байлаа. Мөн УИХ-ын гишүүн

Ч.Улаан, Ц.Даваасүрэн нар уг хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа, гэхдээ ирэх оны төсөвтэй уялдуулж ярилцах шаардлагатай гэсэн байр суурийг илэрхийллээ.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтүүдийг хэлэлцлээ

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 09 дүгээр дүгнэлтийг хэлэлцлээ. Үндсэн хуулийн цэц өнгөрсөн есдүгээр сарын 21-ний өдөр дунд суудлын хуралдаанаараа Сонгуулийн тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.5 дахь хэсэгт “Нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасагдсаны улмаас дахин сонгууль явагдсан бол хасагдсан нэр дэвшигч хүн зургаан жилийн хугацаанд сонгуульд нэр дэвших болон төрийн албанд томилогдох, сонгогдох эрхээ алдах ба урьд явагдсан сонгуулийн сурталчилгааны болон зохион байгуулалтын бүх зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн дүгнэлтийг гаргажээ. Тиймээс дээрх заалтын үйлчлэлийг 2016 оны есдүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн юм. Тэгвэл дээрх дүгнэлтийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд 100 хувь хүлээн зөвшөөрөх нь зүйтэй хэмээн үзлээ. Мөн өдрийн хуралдаанаар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийг төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэдээр ахлуулан байгууллаа.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Д.Баттулга АН-ын дүүргийн сонгуулийг удирдана

АН-ын сонгуулийн төв штаб хуралдаж, нийслэлийн дүүргүүдийг хариуцсан сонгуулийн менежерээр Д.Баттулгыг томилжээ. Тэрбээр өнгөрсөн дөрвөн жил Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ажиллаж байсан

юм. Энэ хугацаанд Улаанбаатар хотыг хөгжүүлэх, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх хүрээнд олон даацтай шийдвэрүүд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарч, хот хэрэгжүүлж байв.

УИХ-ын дарга Баянхонгор аймагт ажиллаж байна

УИХ-ын дарга М.Энхболд өчигдөр Баянхонгор аймагт ажиллаа. Тэрбээр хоёр өдөр үргэлжлэх орон нутгийн томилолтоо Баянхонгор аймгаас эхлүүлж байгаа бөгөөд УИХ-ын гишүүн М.Билэгт, Г.Занданшатар, Л.Элдэв-Очир, УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг болон албаны бусад хүмүүс дагалдан ажиллаж байгаа юм. УИХ-ын дарга дагалдан яваа төлөөлөгчдийн хамтаар Баянхонгор аймгийн Номун далай цогцолбор сургуулийн үйл ажиллагаатай танилцсан юм. Тус

сургуульд 2400 гаруй сурагч, 105 багш, 50 гаруй ажилтан, ажилчид болохыг сургуулийн захирал Ц.Алтангэрэл танилцууллаа. Нийт багш нарын 84 хувь нь мэргэжлийн зэрэгтэй, 30 гаруй хувь нь магистр, магистрантур юм байна. Боловсролын шинэчлэлийн хүрээнд сургалтын төлөвлөгөө уян хатан болсонтой холбогдуулан ахлах ангийн сурагчдад хичээл сонголтын хувьд олон бүлэгтэй, суралцагч олонтой, шилдэг арга зүйтэй багш нартай, сургалтын техник хэрэгсэл сайтай, эцэг эх олон нийтийг үйл ажиллагаанд татан оролцуулж, хамтын ажиллагаа сайжирсан, сурагч нэг бүрийн өөрийн сонголтоор анги бүлгийн зохион

байгуулалт хийгдэж байгаа учир сүүлийн гурван жилийн хугацаанд суралцагчийн тоо 160-200-аар нэмэгдэж байгаа ажээ. Энэ үеэр сургуулийн барилгыг шинэчлэх шаардлагын талаар танилцуулж, 2017 оны улсын төсөвт 1500 хүүхэд суралцах шинэ сургууль, сурагчдын дотуур байрны зураг төслийг хийж, барих хөрөнгийг шийдвэрлүүлэх хүсэлтээ уламжлав. Үүний дараа Баянхонгор аймгийн иргэдтэй уулзалт хийж, УИХ-ын үйл ажиллагаа, ээлжит бус чуулганаар баталсан хууль, тогтоомжийн талаар танилцууллаа. УИХ-ын даргын орон нутгийн томилолт үргэлжилж байна.

Монголд CISM-ын Удирдах зөвлөлийн хурлыг хийх санал тавив

УИХ-ын гишүүн, засгийн газрын гишүүн батлан хамгаалахын сайд Б.Бат-эрдэнэ олон улсын цэргийн спортын хорооны ерөнхийлөгч, хурандаа А.Хакеем Ал Шиног төрийн ордонд хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Б.Бат-эрдэнэ “Спорт оор нөхөрлөгчдөө” уриатай олон улсын цэргийн хорооны Ерөнхийлөгч, тус хорооны удирдлага та бүхэнтэй уулзаж байгаадаа сайд хүний хувьд болон спортын хүний хувьд сэтгэл маш өндөр байна. Эгнээндээ дэлхийн 134 орныг нэгтгэсэн олон улсын цэргийн байгууллагад Эвсэгт хүчний спортын хороо гишүүн байдаг нь Батлан хамгаалах яамны хувьд нэр төрийн хэрэг юм. Манай улсын Зэвсэгт хүчин офицер, ахлагч цэргийн алба хаагчид нь дэлхийн цэргүүдтэй мөр зэрэгцэн халуун цэргүүдэд энхийг дэмжих үйл ажиллагаанд оролцож, олон

улсын тавцанд нэр алдраа цуурайтуулахын зэрэгцээ цэргээр овоглосон бусад орны шилдэг тамирчидтай уралдаж, өрсөлдөж, нөхөрлөж байгаад бахархаж байна. Саяхан л бид танай байгууллагад шинэхэн гишүүн орон байсан бол өнөөдөр CISM Зүүн Хойд Азийн тэмцээнүүдийг 2017 онд хүлээн авч зохион байгуулагчаар дэмжигдсэнд сэтгэл хангалуун байна. Та бүхэн ч үүнд сэтгэл гаргаж тусалж, дэмжинэ гэдэгт итгэлтэй байна. Бид хичээх болно.

Цаашид хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжино гэдэгт итгэлтэй байна” гэлээ. Уулзалтын төгсгөлд Олон улсын Цэргийн Хорооны Ерөнхийлөгч, хурандаа А.Хакеем Ал Шино 2018 онд Монгол улсад CISM-ын Удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулах санал батлан хамгаалахын сайдад тавьлаа.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ**
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ**
88873012

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД**
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН**
96017873

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ**
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ**
99173710

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ**
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн **Н.ПУНЦАГБОЛД**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757


Редакцийн хаяг: **Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

“Í añáí òòðøààà òáí èēñáí
 òáí èéí òàà í èéáýí ä ò°ēñ°í
 ò°éá°ðēéí òí áí ðòí é öýí æýýä
 è °òð° òá÷ ááéáàà áí èí òí ñ
 áèø ò°ð çàñàà ñàéí áàà Í í í áí è
 Òēñúí ò°ñá°ñ í °í á° °á÷
 ááéáàà òì àèø.”

Эрүүл мэндийн сайд асан
С.Ламбаа

ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛБАНК ЮУ ХИЙГЭЭД БАЙНА АА

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Гэх мэт байр сууринаас хараад, хараат бусаар ажиллах нь гэж ойлгож байлаа. Гэвч саяхан тэрбээр “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг өргөн мэдүүлэх үеэрээ 100 ам.метр хүртэлх орон сууцанд ипотекийн зээл олгох асуудлыг дэмжинэ, санхүүжүүлнэ гэх маягийн юм ярьсан. Цахим сайтуудаар хэлсэн, ярьсан нь “давхиад” эхлэхээр дахиад л “Монголбанк хараат бус ажиллаж чадах уу” гэдэг асуулт гарч ирчихэж байна. Яах вэ, 100 ам.метрийг зарчмын хувьд дэмжинэ, гэхдээ эдийн засгийн нөхцөл байдалтайгаа уялдуулна гэдгийг ч нэмж хэлсэн л дээ. Гэхдээ л хараат бус байна гэснээсээ ухарчих вий дээ гэж эмээгээд байна. Уг нь дэмжихгүй л байх ёстой байсан. Тэр байр сууриа л хадгалж байсан нь зөв шүү дээ. Өнөөдөр эдийн засгийн нөхцөл байдал ямар байгаа билээ. Юун ипотекийн зээл санхүүжүүлэх. Тийм чадавхи манай Засгийн газарт байхгүй. Улсын төсөв тэртэй тэргүй хүрэлцэхээсээ өнгөрчихөөд байна. Одоо бид эдийн засгаа яаж сэргээж авч, төсвөө алдагдлаа нөхөж, бондын өрөө төлөх вэ гэдэг дээр тархиа гашилгаж байгаа. Янз бүрийн боломжийг судалж байна. Яг энэ үед ипотекийн зээл ярьж суух хэрэгтэй юу гэдгийг бодолцох л хэрэгтэй. Засгийн газар яах вэ, тэртэй тэргүй амлалт өгөөд сонгогдсон улстөрчдөөс, нэг намын төлөөллөөс бүрдсэн л газар. Тийм болохоор ард түмэнд таалагдах гэсэн, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх ажлыг л хийнэ. Зүгээр л “нүдээ аниад” дайраад байгаа юм. Харин үүнийг нь Монголбанк “хазаарлах” ёстой бус уу. Өмнөх дөрвөн жилд ипотекийн зээлийг Монголбанк мөнгө хэвлэх замаар л санхүүжүүлсэн биз дээ. Булавч бултайж, даравч далдайсан үнэн энэ. Харин сүүлд нь ийм эрүүл бус аргаас татгалзаж, ипотекийн зээлийн өмчлөлийг Монголбанкнаас Засгийн газарт шилжүүлсэн. Улмаар Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг гаргаж, ипотекийн санхүүжилтийн асуудлыг зөвөөр шийдэхээр оролдсон. Харамсалтай нь саяхан УИХ 40 дүгээр тогтоол гээчийг гаргаж, энэ хуулийг хүчингүй болгочихлоо. Ингэснээр ипотекийн зээлийн өмчлөл эргээд Монголбанкны мэдэлд

...Гагцхүү одоо л энэ хөтөлбөрийг заавал хэрэгжүүлэх гэж мөнгө хэвлэж, “сэхээн”-д байгаа эдийн засгийнхаа дээрээс “лантуудах” шаардлага алга. Уг нь, Засгийн газар энэ хөтөлбөрийн өмчлөлийг өөртөө аваад, улсын төсөвт мөнгө суулгаад явбал зөв болох ёстой байлаа...

ирж байна. Засгийн газар өөрөөсөө асуудлыг түлхэж, ипотекийг Монголбанкнд наачихлаа. Тэгсэн мөртлөө ипотекийн зээлд хамрагдах орон сууцны ам.метрийн хязгаарыг 100 болгогдож зөвлөд байгаа сурагтай. Зөвлөх ч юу байх вэ дээ, тулгаж байхгүй юу. Үндсэндээ мөнгө хэвлээд ч хамаагүй санхүүжүүлээд яв гэж байгаагаас ялгаа юу байна. Яах вэ, мөнгө хэвлээд, санхүүжүүлээд, ард түмний өмнө сайн хүмүүс болж харагдаж болох л байх. Гэвч өнөөх төсвийн алдагдал чинь тэлж, буруу замаараа дахиад илүү хол явах болох гээд байна. Буруу замаар явж байгаагаа мэдсэн бол даруй буцсан нь дээр биз дээ. Тэгж байж зөв замдаа орно. Гэтэл тэр чигээр нь явуулах гээд байгаа нь юу гэсэн үг билээ. Өнөөдөр ипотекийн зээл авсан хүмүүсийн эргэн төлөлтөөс сардаа 20-30 тэрбум төгрөг л орж ирж байгаа юм билээ. Гэтэл гаргах шаардлагатай зээл нь сардаа 90 тэрбумд хүрчихдэг гэсэн тоо байгаа. Энэ зөрүүг ердөө л мөнгө хэвлэх замаар л нөхөж байгаа нь үнэн. Энэ гаж тогтолцоогоо

одоо л засаг хэрэгтэй. Тэгэхийн тулд Монголбанкны хараат бус байдал хэрэгтэй байна. Н.Баяртсайхан Ерөнхийлөгчийн эрүүд, зөв бодлого л шаардлагатай байгаа юм. Төв банк Засгийн газрынхаа бүх бодлого, шийдвэрийг эсэргүүцээд байж болохгүй л байх. Гэвч энэ тохиолдолд зөв гарц хайх цаг болсон. Хэсэг зууртаа зогсоосон ч яах вэ дээ. Ганц хоёр жил зогсоогоод, тэр хооронд иргэдээ урьдчилгаагаа цуглуулж бай гэж яагаад болохгүй гэж. Тэгээд эдийн

засаг сайжраад, улс төсвийнхөө алдагдлыг багасгаад, байдал дээрдэхээр дахиад өгч болно шүү дээ. Бүр найм биш таван хувиар ч өгсөн болно. Гагцхүү одоо л энэ хөтөлбөрийг заавал хэрэгжүүлэх гэж мөнгө хэвлэж, “сэхээн”-д байгаа эдийн засгийнхаа дээрээс “лантуудах” шаардлага алга. Уг нь, Засгийн газар энэ хөтөлбөрийн өмчлөлийг өөртөө аваад, улсын төсөвт мөнгө суулгаад явбал зөв болох ёстой байлаа. Гэвч тэгсэнгүй. Сая Хятадын нэг дарга айлчлахад ипотекийн

зээлийн хөтөлбөрийг урагшлуулах хөрөнгө мөнгөний асуудлыг шийдвэрлэх гарц хайж, ярилцаж, хүсэлт тавьсан л байна билээ. Мөнгө хэвлэснээс л дээр. Эсвэл одоо ипотекийн зээлийн эргэн төлөлтөөс сард орж ирж байгаа 20-30 тэрбумаараа л зохицуулаад явж ч болно биз дээ. Эдийн засгаа “алах”-аас өөр арга хэрэглэж байвал ипотекийн зээл шиг хэрэгтэй хөтөлбөр алга. Харин энэ асуудалд Монголбанк хараат бус байж, эрүүл шийдвэр гаргаасай билээ.

» Үргэлжлэл

МЭДЭГДЭЛ

Гэтэл компаниудыг шилжүүлэн авснаас хойш 5 жилийн хугацаанд та Голомт банкинд дээрх өр төлбөрөө төлөлгүй зайлсхийж, банкны хууль ёсны эрх ашгийг хохироож байна. Түүгээр ч барахгүй өр төлбөрөө сайн дураар төлж барагдуулаагүйн улмаас Голомт банк шүүхээр дээрх төлбөрүүдийг нэхэмжилсэн иргэний хэрэг маргаануудыг хянан шийдвэрлүүлэхгүй удаах, саад болох бүхий л арга саамыг хэрэглэн, шүүгчээс татгалзах, үндэслэлгүй хэрэг маргаан үүсгэх, тэр ч бүү хэл өмнөх эзэмшигч ОХУ-ын иргэн С.В.Паушоккийн эсрэг прокурорын байгууллагад эрүүгийн хэрэг үүсгүүлэх зэргээр шүүх хуралдааныг нийт 30 гаруй удаа хойшлуулж, хугацаа авсаар өнөөдрийг хүрлээ. Голомт банкны шүүхээр нэхэмжилж буй төлбөрт танай компаниудад олгосон зээл, аккредитив, тэдгээрийн хүүний төлбөрөөс илүү зүйл байхгүй болно.

Ингэх хугацаандаа барьцаа хөрөнгүүдийг бусдад зөвшөөрөлгүй шилжүүлэх, нөөцийг нь худалдах, хууль бус олборлолт явуулах зэргээр зөвхөн хувьдаа асар их хэмжээний ашиг олж, төлбөр хариуцагч компаниудыг санаатайгаар төлбөрийн чадваргүй болгох, дампууруулах зэрэг хууль бус ажиллагаа явуулж байгаа тань өдрөөс өдөрт ил болсоор байна.

Түүнчлэн, энэ хугацаанд гарсан Улсын дээд шүүх, анхан шатны шүүхийн шийдвэрүүдийг үл хүндэтгэн шүүгч нарт Голомт банк нөлөөлсөн мэтээр өр үндэсгүй гүжир гүтгэлэг тарааж, шүүх болон Голомт банкны нэр хүндэд халдах, олон нийтийн сэтгэл санаанд зүй бусаар нөлөөлөх оролдлого хийж байгаа нь хууль зөрчсөн, ёс зүйгүй, явуургүй үйлдэл болно. Тухайлбал, Т.Ганболд нь “Алтандорнод Монгол” ХХК-ийн Монгол Улсад төлөх татварын 70 орчим тэрбум төгрөгийн өр төлбөрийг Голомт банкны барьцаанд байсан, дээрх үнээс хэд дахин бага үнэлгээ бүхий “Востокнефтегаз” ХХК-ийн эд хөрөнгөөр, барьцаалагчийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр татварын өрөнд тооцон шилжүүлж, өөрийн асар их хэмжээний татварын өрөө хаасан нь Монгол Улсын төр болон барьцаалагч Голомт банкныг онц их хэмжээгээр хохироосон гэмт хэргийн шинжтэй үйлдэл болно.

Дээрх барьцаатай холбоотой иргэний маргааныг Улсын дээд шүүх шийдвэрлэхдээ барьцааг хүчинтэй гэж үзэж “Востокнефтегаз” ХХК-ийн зээлийн өр төлбөрийг дээрх барьцаа хөрөнгөөс хангуулахаар эцэслэн шийдвэрлэсээр байтал шүүхийн шийдвэрийг шүүж, нөхцөл байдлыг гуйвуулан хууль бус шийдвэр мэтээр олон нийтэд тарааж байгааг тань дээрх гэмт үйлдлүүдээ нуун далдлах оролдлого гэж үзэхээс өөр аргагүйд хүргэж байна.

Иймд, Монгол Улсын иргэн Тордайн Ганболд танаас Монгол улсын шүүхийн шийдвэрийг хүндэтгэн биелүүлж, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, Голомт банкинд төлөх өр төлбөрийн үүргээ хариуцлагатайгаар биелүүлэхийг шаардаж байна.

Түүнчлэн, Монгол Улсын иргэн Тордайн Ганболд та болон танай хамт олноос нэгэнт шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн болон бусад асуудлуудын талаар ёс зүйгүй мэдэгдэл хийх, гүтгэсэн гүжирдлэг тараах явдалаа зогсоохыг шаардаж байна.

Голомт банк

Дугаарын **60** мөр

Хүүхэд рүү “хүрз далайх” чинь ариун явдал уу

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Уг нь МАН-ынхан сонгуулиар хүүхэд бүрт хүүхдийн мөнгийг олгоно, хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулна, “Цалинтай ээж” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ, хүүхдээ гурван нас хүртэл нь асарч байгаа эхчүүдийн НДШ төлсөн хугацаа тасрахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ гэх зэргээр иргэдэд амаа цангатай “тайхамшигт” амлалтуудыг өгсөнсөн. Тиймээс ч хүүхэд, хөгшиддөө хайртай хэн бүхэн Ардын намыг хоёр гараа өргөн дэмжсэн хэрэг. Гэтэл тэд сонгогдсон даруйдаа сонгогч олонд хатуухан харну бариад байна.

Тухайлбал, Хүүхдийн мөнгийг ялгавартайгаар буюу амьжиргаа тогтоох судалгааны 1-10 дугаар бүлэгт хамрагдсан өрхийн хүүхдүүдэд 20 мянган төгрөгийг үргэлжлүүлэн олгохоор болсон. Энэ нь “Хүүхэд бүрт хүүхдийн мөнгийг олгоно” гэсэн амлалтдаа баяртай гэж хэлсэн үйлдэл болов. Өөрөөр хэлбэл, хөргөгчтэй, будаа агшаагчтай, зурагттай, тоос сорогчтой, угаалгын машинтай бол таны хүүхдэд тэд мөнгө өгөхгүй гэсэн үг. Ийнхүү хүүхдүүдэд ялгавартай хандаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн “Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх” гэснийг гээд олон хууль тогтоомж зөрчиж байгаар гэдгээ тэд мэдэж баймаар. Эсвэл хүүхэд хүн биш хэрэг үү.

МАН-ынхан “Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулна” гэх сайхан амлалт өгөөд байсан нь саяхан. Гэтэл Засгийн эрхийг авсан даруйдаа “Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль”-ийн үйлчлэлийг 2021 он болгон өөрчилсөн. Энэ нь гэртээ цоожлогдох бус цэцэрлэгт явах байсан мянга мянган бяцхан үрсэд шийтгэл болсон шийдвэр гэдгийг яагаад ухаарахгүй байгааг гайхах юм. Үгээ хэлж, эрхээ хамгаалах чадваргүй гэдгээр нь хүүхэд рүү чиглэсэн асуудал бүрийг энэ мэтээр баллаж болохгүй байлтай. Мөн “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн хугацааг мөн л хойшлуулчихлаа. Энэ мэтээр тэдний хүүхэд рүү “хүрз” далайх үйлдэл зогсохгүй байна. Харин хамгийн эмгэнэлтэй нь хүүхдийн ашиглах гарцаа тэд аль хэдийнэ олчихсон байгаа юм. Тодруулбал, үнэмлэхүй олуулаа сонгогдсон цагаасаа буюу 7-10 дугаар сард хүүхдийн мөнгийг өгөлгүй хураасан. Харин одоо орон нутгийн сонгуулийн өмнө эцэг, эхийнх нь саналыг худалдан авахаар 7-10 дугаар сарын мөнгийг сонгуулийн өмнө бөөнөөр нь өгөх гэнэ. Энэ нь мөнгө авч байгаа юм чинь биднийг сонго гэсэнтэй ямар ч ялгаагүй харагдаж байгаа биз.

Уг нь хүүхдийн мөнгө халамж биш гэдгийг МАН-ынхан хэнээр ч хэлүүлэлтгүй мэдэж баймаар. Хүүхдийн мөнгө хасалгүй ганцхан тендер хасахад, шийдэгдчих асуудал байсан. Тэгээд ч хэдхэн хүүхдийн 20 мянган төгрөгийг хаслаа гээд элгээрээ мөлчихөөд байгаа гэх улс орны эдийн засаг сэргээд сүйд болохгүй нь юу л бол доо.

ДЭЛХИЙ

ТУРК ОНЦ БАЙДАЛ ТОГТООХ ХУГАЦААГ ГУРВАН САРААР СУНГАЛАА

Б.ДАВААХҮҮ

Одоогоос сар гаруй хугацааны өмнө Туркийн цэргийн зарим албан тушаалтнууд төрийн эргэлт хийхийг оролдсон. Гэсэн ч тэдний өдүүлсэн тэмцэл хотын иргэдийн эсэргүүцэлтэй тулгарсны улмаас хагас өдрийн дараа бүтэлгүйтлээр төгссөн билээ. Энэ үеэр нийтдээ 240 хүн амь үрэгдсэн бөгөөд тэдний дунд хотын гэм зэмгүй иргэд олноороо багтаж байжээ. Цэргийн эргэлттэй холбоотойгоор эдүгээг хүртэл хэдэн арван мянган цэргийн алба хаагч баривчлагдан саатуулагдаж, төчнөөн тооны төрийн алба хаагчид аажлаасаа халагдсан бол харин гол удирдагчийг нь АНУ-д орогнож буй шашин судлаач Гюлен хэмээн Туркийн тал хардаж байгаа юм. Тэгвэл Туркийн Засгийн газар цэргийн эргэлтээс хойш тогтоосон онц байдлаа дахин гурван сараар сунгажээ. Тэд террорист бүлэглэлүүдтэй тэмцэж, бүрэн устгахын тулд илүү их цаг хугацаа шаардлагатай гэж үзсэний улмаас ийнхүү хугацааг сунгах шийдвэрт хүрсэн байна. Өнгөрөгч долдугаар сард Туркийн зарим цэргийн алба хаагчид төрийн эргэлт хийхийг завдсан хэдий ч, амжилтгүй болсон байдаг. Үүний улмаас тус улсын Засгийн газар парламентын зөвшөөрлийг авалгүйгээр хууль баталж, онц байдал зарласан бөгөөд цэргийн эргэлт хийх төлөвлөгөөнд оролцсон гэх

30 мянга гаруй төрийн алба хаагчдыг баривчилж, 80 мянга гаруй олон нийтийн байгууллагын ажилтнуудыг ажлаас нь халах арга хэмжээ авсан юм. Түүнчлэн, 12 мянган цагдааг ажлаас нь халсны 2523 нь орон нутгийн цагдаагийн газрын дарга нар байжээ. Мөн цаашдаа ч энэ мэт үйл ажиллагаа, төрийн эргэлтийг тойрсон эцэс төгсгөлгүй баривчлалыг үргэлжлэх төлөвтэй байна. Засгийн газраас гаргасан шийдвэр ёсоор онц байдал тогтоох тухай зарлигийн хугацааг энэ сарын 18-ны өдрөөс эхлэн сунгахаар болжээ. Парламентад эрх баригч намынхан олонхи болсон тул эл шийдвэр дэмжигдэх нь гарцаагүй юм. Гэвч сөрөг хүчин онц байдал нэрийн дор хууль бус баривчлалыг үргэлжлэхийг сануулж, эсэргүүцэж буйгаа илэрхийллээ.

Туркийн Засгийн газрын хувьд цэргийн эргэлтийг лалын хэт даврагч бүлэглэлийн удирдагч, шашин судлаач нэрт сэтгэгч Гюлен Фетхуллахыг хөшигний араас удирдсан хэмээн хардаж, түүний орогнож буй АНУ-аас түүнийг өөрийн улсын талд шилжүүлэн өгөхийг шаардсан. Гэхдээ АНУ-ын тал одоогийн байдлаар эл асуудалд тодорхой байр суурийг илэрхийлэхээс зайлсхийж байгаа юм. Түүнчлэн Прокурорын газраас АНУ-д орогнож буй Гюленд бүх насаар нь хорих ял болон 1900 өдрийг чанга дэглэмтэй хорих ангид өнгөрүүлэх ялыг төлөвлөсөн байдаг.

Нүцгэн хөгжөөн дэмжигчдийг баривчилжээ

Малайзын цагдаагийн алба хаагчид нийслэл Куала Лампур хотын зах хэсэгт зохион байгуулагдсан "Malaysian Grand Prix 2016" тэмцээнийг дотуур өмднөөс өөр хувцастгүйгээр хөгжөөн дэмжсэн залуусыг баривчилжээ. Нийтдээ есөн австрали залуу дотуур өмд дээрээ Малайзын төрийн далбааг хэвлэсэн байсан нь ийнхүү асуудал үүсгэсэн аж.

Цагдаагийн газраас мэдээлж буйгаар тэмцээн дуусмагц малайзыг төрийн далбааг доромжилсон залуусыг барьж саатуулсан гэнэ. Тэднийг "Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах зорилгоор төрийн далбааг санаатайгаар гутаасан" гэх үндэслэлээр баривчлан хэргийг шалгаж буй ажээ. Баривчлагдсан залуус 25-29 насныхан байсан бөгөөд бүгд жуулчид байсан гэнэ. Хууль дүрэмд заасны дагуу тэднийг дөрөв хоног саатуулах юм байна. Малайзын төрийн далбааг хэвлэсэн дотуур хувцастай хөгжөөн дэмжигчдийн зураг тус улсын цахим ертөнцөд цацагдсан даруйд маш богино хугацаанд өргөн хүрээнд тархан малайзынуудын уур бухимдлыг төрүүлжээ. Мусальман шашинтнууд хүн амын ихэнхийг эзлэх Малайзад тус улсын ёс журмыг зөрчсөн явдал хэд хэдэн удаа гардаг бөгөөд энэ тохиолдолд гадаадын жуулчид ихэвчлэн торгууль төлөөд нутаг буцдаг юм.

Кашмирын бүсэд хоёр хүн гэмтэв

Энэтхэг, Пакистаны хилийн зурвасын асуудлаар маргаантай байдаг кашмирын бүс нутагт хоёр хүн гэмтэж, хурцадмал байдал үргэлжилсээр байгааг орон нутгийн сайтууд мэдээлж байна. Хэргийг тодруулбал, Кашмирын бүс нутаг дахь Энэтхэгийн харьяанд байдаг Жамму Кашмир мужид буу, тэсрэх бөмбөгөөр зэвсэглэсэн хэсэг этгээдүүд Энэтхэгийн цэрэг болон хилийн хамгаалалтын албаныхантай мөргөлдөж, ширүүн дайн өрнөх үед хилийн хамгаалалтын нэг алба хаагч нас барж, нэг хүн гэмтжээ. Зэвсэгт бүлэглэл хэргийн газраас зугтсан бөгөөд албаныхан тэдний үлдээсэн эд хэрэгслэлээс афганистаны хэт даврагч бүлэглэлийнхэн байсныг олж тогтоосон байна. Энэтхэгийн цэргийн арми өнгөрсөн сарын 29-ндхэт даврагч бүлэглэлийг устгахын тулд Пакистаны талтай буудалцсан билээ. Түүнээс хойш Пакистаны тал хил дагуу амьдардаг оршин суугчдаа нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авч эхэлснээр тухайн бүсийн байдал хурцдаж эхэлсэн юм.

Эстони түүхэндээ анх удаагаа эмэгтэй Ерөнхийлөгчтэй болов

Эстонийн парламент энэ сард бүрэн эрхийнх нь хугацаа албан ёсоор дуусч буй Ерөнхийлөгч Тоомас Илвесын залгамжлагчийг сонголоо. Тодруулбал, анх удаагаа эмэгтэй хүнийг сонгосон нь түүхэн явдал болж байна. Эстон улсын анхны эмэгтэй Ерөнхийлөгчөөр Европын холбооны гадаад харилцааны байгууллага, Европын шүүхийн шинжилгээний хүрээлэнд шинжээчээр ажиллаж байсан туршлагатай 46 настай Керсти Калжуйлайд гэгч эмэгтэй сонгогджээ. Тэрбээр

санхүүгийн байгууллагад ажиллаж байсан туршлагатайгаас гадна Ерөнхий сайдад мөн зөвлөж байсан аж.

Улмаар 2004 оноос ЕХ-ны шүүхийн шилжилгээний хүрээлэнд ажиллаж эхэлсэн байна. Бүсгүй энэ сарын 10-нд тангарагаа өргөж, албан ёсоор Ерөнхийлөгчийн албан тушаалд томилогдох ажээ. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа таван жил бөгөөд бэлгэдлийн үүрэг гүйцэтгэдэг байна.



"Тоёота" ярьдаг робот худалдаанд гаргана

Японы автомашин үйлдвэрлэгч "Тоёота Мотор" компани бага оврын хүний хэлээр ярьдаг "Kirobo mini" гэх роботыг ирэх жилээс эхлэн дэлхий даяар худалдаанд гаргана гэдгээ албан ёсоор зарлалаа. Том өхөөрдөм нүдтэй Киробо мини робот нь сансрын нисгэгч Коичио Ваката нарын хамт дэлхийгээс анх удаагаа сансарт ниссэн туршлагатай Киробо гэх роботын жижигрүүлсэн хувилбар аж. Роботын өндөр нь ердөө 10 сантиметр гэнэ. Харин үнийн хувьд 39800 иэн байх юм байна. Гэхдээ энэ нь татвар оруулаагүй дүн гэдгийг албаныхан тодотголоо. Киробо мини робот нь хүнтэй харилцан яриа өрнүүлэх чадвартай бөгөөд хүний сэтгэлзүйн онго аясыг ч илэрхийлэх чадвартай аж. Роботын энэ сарын 7-ныг дуустал үргэлжлэх Азийн хамгийн том электроникийн "SEATEC JAPAN" үзэсгэлэнд дэлгэж олон танилцуулжээ.

Анагаах ухааны салбарын Нобелийн шагналтан Японоос төрлөө



Энэ долоо хоногт дэлхийн шилдэг эрдэмтэн бүтээлчдийг шаалгаруулдаг Нобелийн шагналын шинэ эзэд тодорсоор байна. Тодруулбал, анагаах ухааны Нобелийн шагналыг Японы Технологийн Институтын биологич, эрдэмтэн Ёсинори Осуми "өөрийгөө идэж, дахин төлжүүлдэг" эсийн механизмыг нээн хүртжээ. Эрдэмтэд 1960-аад оноос уг эсийн талаар нээлтийг хийж байсан ч тийм ч гүнзгий судалгаа хийгээгүй байсан юм. Эрдэмтэн Осуми 1990-ээд оноос уг эсийн механизмыг туршиж

эхэлсэн бөгөөд анх талхны хөөлгөгч дээр туршилтаа хийж байжээ. Энэхүү "өөрийгөө идэж, төлждөг эс" нь эс доторх нянг устгадаг бөгөөд хэрэв эс задарвал настай хүмүүст ихэвчлэн тохиолддог хоёрдугаар зэргийн чихрийн шижин, Паркинсоны өвчнүүдийг бий болгох аюултай аж. Англиар "autophagy" гэж нэрлэгддэг уг эсийг 1960-аад оны үед эрдэмтэд эсийн бүтцийг судалж байх явцдаа анх нээж байжээ. Тэр үед эрдэмтэд эс нь өөрийгөө идээд, өөр хэлбэрт шилжин, задарч болдогийг нээсэн юм.

"ШИНЭ ТӨГӨЛ" ЦЭЦЭРЛЭГТ ТАВТАЙ МОРИЛ



Олон Улсын стандартад нийцсэн "Шинэ төгөл" цэцэрлэг "Маршал таун" хотхонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн эхлэлтээ авч эхэллээ. "Шинэ төгөл" цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.

Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай

цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхдэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан,

хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлэнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхдэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байдлаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.

ПЛАНЫ БЯЦХАН ЧРС ЗӨВ МОНГОЛ ХҮН БОЛНО

Холбоо барих утас: 99094864

ОНЦЛОХ ХУУДАС

Speak out

ЗАСГИЙН ГАЗРЫН 100 ХОНОГТ АМЖУУЛСАН АЖИЛД ИРГЭД “F” ДҮН ТАВИВ

Ж.МЯГМАР

Монгол Улсын 29 дэх Ерөнхий сайдаар тохоон томилогдсон Ж.Эрдэнэбатын Мэргэжлийн Засгийн газрын 100 хоног болоход хэдхэн хоногийн хугацаа үлджээ. Нэг үгээр хэлбэл, үнэмлэхүй олонхи болсон Ардын нам Засгийн газраа байгуулж, бодлого хэрэгжүүлэх болсноос хойш гурван сар болох гэж байгаа юм. Тиймээс “Монголын мэдээ” сонин энэ удаагийн дугааргаа Засгийн газрын 100 хоногт амжуулсан ажилд иргэд ямар дүн тавьж байгаа талаар байр суурийг нь сонслоо.

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН



А.Эрдэнэцэцэг:
Хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт өгнө гээд амлаад байсан яасан

/Сүхбаатар дүүргийн иргэн/

-Энэ Засгийн газар маш их өртэй, их л хэцүү улс

орон хүлээж авсан гэх юм. Тиймээс л хүүхдүүдийн мөнгө, ахмадуудын тэтгэврийг хасч байна гэсэн. Гэтэл өмнө нь энэ асуудал яагаад яригдахгүй байсан юм бэ гэдгийг гайхаад байх юм. Хэдийгээр үнэмлэхүй ялалт байгуулж олуулаа төрийн толгойд суусан ч жаахан дэгтэй байх хэрэгтэй

байна. Миний хувьд УИХ-ын сонгуулиар МАН-д саналаа өгсөн. Улс орноо сайхан болгох байх гэж итгэж, найдсан хэрэг. Надаас өөр олон хүн итгэж найдаад, хүлээж суугаа гэдэгт ч итгэлтэй байна. 100 хоног гэдэг бол урт хугацаа. Гэтэл энэ хугацаанд тийм ч их ажил амжуулж чадсангүй

гэж би хувьдаа харж байгаа. Харин өмнөх Засгийн газрын янз бүрийн шийдвэрүүдтэй зууралдсаар байгаад таарлаа. Тиймээс ч тун удахгүй болох орон нутгийн сонгуулиар нэлээд бодож байж сонголтоо хийнэ гэж бодож байна. Хүүхдийн мөнгийг хүүхэд бүрт өгнө гээд амлаад байсан

яасан. Одоо болохоор угаалгын машинтай, ус буцалгагчтай эсэхээр нь ялгаж өгнө гээд байх юм. Амлаад, хуураад гараад ирчихсэн. Одоо яасан ч яах вэ гэж боддог бололтой.



Х.Эрдэнэчимэг: МАН-ынхан гаргаж байгаа шийдвэр, ярьж байгаа зүйлээ жаахан бодох хэрэгтэй

/Хан-Уул дүүргийн иргэн/

-Энэ эдийн засгийн хямрал гэдэг зүйлийг дээр, дооргүй

яриад иргэдээ улам хямраагаад байна уу даа гэж харж байна. МАН-ынхан Засгийн эрхийг авсан цагаасаа л ядарсан иргэддээ ирдэг хэд гурван төгрөгийг бүгдийг нь хасаад танаад байх юм. Би оюутан охинтой. Гэтэл охины минь авдаг байсан 70 мянган төгрөгийг өгөхгүй байгаа. Уг нь маш их хэрэг болдог байсан юм. Жилээс жилд төлбөр нь

нэмэгдээд охиноо сургахад хэцүү байхад, төр засгаас бага ч болов тус дэм болдог байсан зүйл. Сонгуулиар МАН-ын нэр дэвшигчид оюутны зээлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж байсан. Тухайн оюутан сургуулиа төгсөөд, ажил хийгээд буцаагаад төрд төлж болно хэмээн амлаад байсан юм. Тэр ажил нь лав энэ жилдээ багтаж хэрэгжихгүй

шинжтэй. Охин бид хоёр төлбөрөө яаж төлно дөө гэж бодож сууна. Монгол Улсад хэт ядуу, хэт баян хүн их байна. Тиймээс ч оюутны 70, хүүхдийн 20 мянган төгрөг амьдралд ямар их дэм болдог гэдгийг гишүүд ухаарахгүй, мэдэхгүй байх шиг байна. Миний хувьд сав угаагч ч хамаагүй хийгээд цалинтай болох хүсэл байв ч хөгшин

гээд ажилд авахгүй байх жишээтэй. Энэ мэтээр ард иргэдийн амьдралд өөрчлөлт гарахгүй л байна. МАН-ынхан одоо орон нутгийн сонгуулиар иргэдийн саналыг авахыг хүсч л байгаа бол гаргаж байгаа шийдвэр, ярьж байгаа зүйлээ жаахан бодох л хэрэгтэй.



Ж.Нямдорж: Нэг намд хэт давуу эрх өгөх дэмий бололтой

/Чингэлтэй дүүргийн иргэн/

-Амлалт өгөөд, гарч байгаа хүмүүст итгэх үнэхээр хэцүү болчихжээ. Сонгууль өнгөрөөд

хэдхэн сар буюу 100-хан хонож байхад амлалтуудаа маргчихсан юм болов уу гэж бодмоор шийдвэр гаргаад байх юм. Сонгуулиар хэчнээн сайхан зүйл яриад байлаа даа. Гэтэл учир мэдэхгүй хүүхдүүдийн мөнгийг өгөхгүй гээд байх юм. Хүүхдийн мөнгийг хасаад л бүхэл бүтэн

улс орны эдийн засаг сэргэх нь юу л бол. Өөр хасах, танах зүйл зөндөө л байгаа. Ер нь нэг намд хэт давуу эрх өгөх дэмий бололтой. Гаргаж байгаа шийдвэрүүд нь нэг талыг барьсан байдаг бололтой. Тиймээс энэ дур зоргоороо хүмүүст хяналт тавих сөрөг хүчин хэрэгтэй юм байна.

Тиймээс одоо болох орон нутгийн сонгуулиар иргэд сайн бодож, сонголтоо хийх нь зөв гэж бодож байгаа. Өнгөрсөн УИХ-ын сонголт буруу байж гэж хэлэх хүн олон байна. Манайхан яг цаг нь тулаад ирэхээр их сонин сонголт хийх юм. Нээрээ сонгуулийн өмнө хүүхдийн мөнгийг бөөнөөр

нь өгнө гэж байсан. Энэ чинь хүмүүсийн саналыг худалдан авахыг санаархаж байгаа нэг хэлбэр байх. Гэхдээ өгсөн үед нь л өгчихлөө гэж харахаас. Тэр мөнгийг чинь хэзээ өгөх бол гээд өдөр, хоног тоолоод сууж байгаа ядарсан хүн олон байгаа шүү дээ.



Х.Баянжаргал: МАН-ыг улсаа хямралаас гаргаж чадна гэж найдаж байна

/Сүхбаатар дүүргийн иргэн/

-Би МАН-ын гишүүн хүн. Тиймээс ч намаа дэмжиж явдаг. Аливаа шийдвэрийг

гаргахдаа ултай суурьтай шийддэг гэдэгт итгэдэг. Гэхдээ “Хамтын тэтгэврийн хууль”-ийг хүлээж байсан олон хүн байсан. Гэтэл “Хамтын тэтгэврийн хууль”-ийг хэрэгжүүлсэнээр хоёр ахмад нэгийгээ үхээсэй гэж бодно гээд болиулчих юм. Энэ мэт шүүмжлэлтэй олон

зүйл хийгээд байна. Миний хувьд энэ удаад орон нутгийн сонгуулиар нам гэхээсээ илүү хүнийг нь харж сонголтоо хийнэ гэж бодож байгаа. Дүүргийн иргэдийн төлөөлөгч гэдэг бол иргэдтэйгээ хамгийн ойр ажиллах итгэл даах хүн байх хэрэгтэй. Гэхдээ МАН-ыг үлдсэн хугацаанд алдаагаа

засч зөв зүйлүүдийг хийнэ гэж найдаж байна. Уг нь АН-ыг бодвол аливаад ултай ханддаг нам. Тиймээс улс орыг хямралаас гаргаж чадна гэж найдаж байгаа.

мөнгө байхгүй болсон гэсэн. Харин нэг сарын тэтгэмж авах нөхцлийг МАН бүрдүүлсэн байна. Энэ мэтээр бидний амьдралтай холбоотой шийдвэрүүдийг шууд гаргах учир залуучуудыг сонгуульд идэвхтэй оролцож байгаарай л гэж уриалмаар байна.



Н.Батбаясгалан: 100 хоногт олонд гайхагдах зүйл хийчихлээ гэж харахгүй байна

/Чингэлтэй дүүргийн иргэн/

-Засгийн газрын хийсэн ажил иргэдийн дунд шүүмжлэл дагуулаад байгаа л харж байна. Түүнээс 100 хоногт олонд гайхагдах зүйл хийчихлээ гэж харахгүй байна. Нэг намыг хэт олноор нь гаргасан учир хэт дур зоргоороо байх шиг байна. Мэдээж сонголтоо

хийж, ардчиллаа дэмжиж чадаагүй залуусын буруу байгаа л байх. Тиймээс залуус аливаа сонгуульд идэвхтэй оролцдог баймаар байна. Бид сонгохгүй байсан ч тэд төрд гаргаад бидэнтэй холбоотой шийдвэрүүдийг гаргах нь ойлгомжтой шүү дээ. Би

оюутны зээлийн хөтөлбөрт хамрагдахаар бэлтгэж байсан боловч тэр хөтөлбөрийг зогсоочихсон. Манай ээж насаараа эмч хийж байгаа хүн. Гэтэл тэтгэвэртээ гарахдаа ганцхан удаа төрөөс 36 сарын тэтгэмж болох 20-30 сая төгрөг авах байсан. Харин одоо энэ

ийм үр дүн гарсан гэдэг зүйл яригдаад байсан. Энэ үнэн байж магадгүй. Залуус маань сонгуулиа өгч сураасай л гэж бодож байна.



Ч.Болор-Эрдэнэ: Залуус маань сонгуулиа өгч сураасай

/Сонгинохайрхан дүүрэг/

-100 хоногт багтааж, оюутнуудын тэтгэлэг зогсоож, автобусны хөнгөлөлтийг үгүй хийж, хүүхдийн мөнгийг зогсоосон л гэж харж байна. Улс орны эдийн засаг хямарчихлаа, өртэй байна гэдэг зүйлийг л ярьж байна.

Гэхдээ одоо тэднийг энэ хямрал гээд байгаа зүйлээсээ гаргаж чадах үгүйг бид хараад суух л үлдэж дээ. Уг нь өнгөрсөн дөрвөн жил зөвхөн Улаанбаатарт гэхэд замын асуудлыг хэрхэн сайжруулсан билээ. Гэтэл ирэх дөрвөн жил

бүтээн байгуулалт ганцыг ч хийхгүй гэсэн. Тиймээс хэнийг сонгож, амьдралаа атгуулж байгаагаа сайн бодож байх хэрэгтэй. Сонголтоо маш зөв хийдэг байх л шаардлагатай байх. Фэйсбүүкээр залуучууд сонголтоо хийгээгүй, тиймээс

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

ТОЛГОЙТЫНХОН ДАРАА ЖИЛ

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

Толгойтын орчимд барилгын том машин эгнэж, барилгын ажилчид шуугилдан, бүтээн байгуулалт өрнөж, хүн амьтны хөдөлгөөн ихсэж, тоос шороо бужигнан байжээ. Гэвч сонгуулийн дараагаас зам барилгын машин харагдахаа больж, Толгойтын оршин суугчид “Замын ажил хэзээ үргэлжлэх вэ” гэсэн бодолтойгоо нөгөө л шороо тоосон дундаа орхигдов. Уг нь Нийслэлийн энэ онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөнд тус замын ажил орсон. Тодруулбал, Сонгинохайрхан дүүргийн Орбитын уулзвараас Толгойтын эцэс, Үйлдвэрчний эвлэлийн гудамж хүртэлх 3.6 км авто замын өргөтгөл шинэчлэлт, 36.75 метр, 48.75 метр урттай төмөрбетон гүүрийг энэ онд ашиглалтад хүлээлгэж өгөх ёстой. Ингэхдээ замын нэгдүгээр хэсэг буюу Үйлдвэрчний эвлэлийн гудамжнаас Толгойтын эцэс хүртэлх замыг долоодугаар сарын 05-нд, Толгойтын эцэсээс Орбитын уулзвар хүртэлх замыг аравдугаар сарын 30-н гэхэд шинэчлэн дуусгаж, арванхоёрдугаар сарын 01-нд бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байна. Гэвч одоогийн байдлаар ямар ч зам ашиглалтад ороогүй учраас бид Нийслэлийн авто замын газрын дарга Ж.Тогтохбаяртай холбогдож зарим зүйлийг тодруулав.

Толгойтын замын ажил яагаад зогссон юм бэ?

39, 48 метрийн урттай хоёр том гүүрийн ажил хийгдэж байгаа. Гүүр нь ашиглалтад орсны дараа хүйтэртэл замын ажил үргэлжлээд хийгдэнэ. Зарим аж ахуйн нэгж, шатахуун түгээх газар, айлууд газраа чөлөөлж өгөхгүйгээс ажил удаашраад байгаа юм. Түүнээс суржигнээд байх асуудал биш. Гүүрийн ажил тасралтгүй явж байгаа. Ямар ч зогссон юм байхгүй. Энэ сарын сүүлээр хоёр гүүр ашиглалтад орно.

Санхүүжилт нь бүрэн орсон юм байна. Тийм үү?

Урьдчилгаа мөнгийг улсаас

өгч байгаа. Энэ ондоо багтаад өгч дуусгана. Оны дараа үлдсэн мөнгийг нь өгнө.

Хоёр гүүр ашиглалтад орсон ч замын ажил цас ортол үргэжилнэ гэсэн үг үү?

Тэгнэ. Замын ажил хүйтэртэл үргэлжилж байгаад зогсоно. Харин ирэх хавраас дулаан орохоор замын ажил үргэлжлэн явагдана. Ер нь наадмаас өмнө ашиглалтад оруулна гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Нийг хэдэн төгрөгийн санхүүжилтээр бүтэж байгаа вэ?

Нийт 74 тэрбум төгрөг төсөвлөгдсөн. Улсын хөрөнгөөр хийж байгаа ажил. Албаны эх сурвалж бидэнд ийн мэдээлэл өгсөн. Тус замыг дөрвөн эгнээ, зорчих хэсгийн өргөнг 14 метр болгож, хоёр талдаа 2.85 метр явган хүний зам, борооны ус зайлуулах шугам, гэрэлтүүлэгтэй болгох юм. Мөн улсын төсвийн хөрөнгөөр Азийн Хөгжлийн Банкны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд барих бөгөөд 230 айлын газрыг чөлөөлөх ёстой гэнэ. Ингээд албаны эх сурвалж замын ажил зогсоогүй гэдэг мэдээлэл өгсөн тул манай сурвалжлах хэсэг бодит байдалтай танилцахаар Толгойтыг зорив.

Улсын төсвөөс нэг ч төгрөг орж ирээгүй учраас компаниуд техникээ барьцаанд тавьжээ

Биднийг очих үед гүүрийн ажил ид явагдаж байлаа. Гүүрийн хажуу талд экскаваторын машин ажиллаж, ажилчид дор бүрнээ зогсоо зайгүй л хөдөлж байгаа харгад. Энэ бол “Тотел Имж” компани гүйцэтгэж байгаа гүүр. Бид юун түүрүүнд тус компанийн геодезийн инженер Д.Батболдтой уулзаж, ярилцсан юм. Тэрбээр “Манай компани 36.75 метр урттай гүүрийн ажлыг гүйцэтгэж байна. Энэ сард суурин асфальтааад нээнэ.

Түүнээс биш хүлээлгэж өгөх хугацаа болоогүй. Одоогийн байдлаар асфальт авах дутуу байгаа. Улсаас хөрөнгө, санхүү огт орж ирээгүй байгаа. Бид өөрсдийнхөө хөрөнгөөр л ажиллаж байна. Энэ жил суурин асфальтыг аваад хөдөлгөөнийг нээнэ. Харин дараа жил өнгөн асфальтыг аваад бүрэн ашиглалтад оруулах юм. Тэгэхээр ажил 90 хувьтай явагдаж байна. Энэ сардаа багтаад гүүрийн хөдөлгөөнийг нээнэ” гэв. Мөн тус компанийн гэрээ хийхдээ энэ жил санхүүжилтийнхээ 30 хувийг өгнө гэсэн ч одоо болтол өгөөгүй байгаа гэдгийг тэрбээр онцолсон. Ингээд Манай сурвалжлах хэсэг Толгойтын эцэст явагдаж буй 48.75 метрийн урттай төмөрбетон гүүрийн барилгын ажлыг сонирхов. Уг гүүрийн ажлыг ЗМЗ компани явуулж байгаа аж. Биднийг гүүрэн дээр ирэх үед мөн л барилгын ажил идэвхтэй явагдаж байсан бөгөөд тус

компанийн захирал Д.Ганбаатар байж таарсан. Тэрбээр “Манай компани гүүрийн ажлыг туслан гүйцэтгэж байгаа. Ажил 95 хувьтай байна. Аравдугаар сарын 17-нд гүүрийн замын хөдөлгөөнийг нээнэ. Нийслэлээс ямар ч санхүүжилт өгөхгүй байна. Нэг ч төгрөг өгөөгүй. Тэрэг техникээ зуурмагийн үйлдвэр, арматурын газарт барьцаанд тавчихсан. Тэгж материалаа авж, барилгын ажлыг зогсоохгүй явж байна. Өөрийнхөө хөрөнгөөр л явж байна. Анх гэрээ хийхэд 23.5 хувийг өгнө гэж тохирсон. Гэвч хураагдсан. Одоо дахиад тавьсан гэсэн. Үнэн худлыг нь мэдэхгүй. Зам хучлага энэ жил явахгүй. 78 айл газар чөлөөлөлтөө хийгээгүй. Энэ ажлыг улс шийдэж өгнө шүү дээ. Хөрөнгө мөнгө өгөхгүй бол айл хашаагаа татахгүй. Түүнийг чөлөөлөх арга байхгүй. Чөлөөлөх мөнгө нь ч нийслэлд, улсад алга” хэмээн бухимдсан. Бухимдах нь арга ч үгүй биз.

Цаасан дээр гэрээ хийсэн ч амьдрал дээр биелэхгүй байхаар хэн ч уурлана. Ялангуяа ардаа хэдэн ажилчинтай, хэдэн айлын амьдралыг авч яваа хүн бухимдах нь зүйн хэрэг. Тус компанийн гүүрийн ажил дуусч байгаа нь илэрхий. Гүүрийн урд талаар ногоон тор татаж хүн явуулахыг хоригложээ. Цемент нь хатаагүй учраас ийн шийдвэрлэсэн гэнэ. Харин гүүрийн зүүн талын явган хүний зам хатсан учраас хүмүүсийг чөлөөтэй нааш, цааш явуулж харгад.

Орбитын уулзвараас Толгойтын эцэс хүртэлх гүүрийн ажлыг гүйцэтгэж байгаа компаниудын бодит байдалтай танилцаад нийм байх аж. Биднийг очих үед гүүрийн барилгын ажил тасралтгүй явагдаж байсан юм. Гүүрийн хөдөлгөөнийг нээх хугацаа дөхсөн болохоор компаниуд ингэж эрчимтэй ажилласантай ч таарсан байж болох. Ямартай ч бодит амьдрал дээр ийм байна.

Нийслэлийн авто замын газрын дарга Ж.Тогтохбаяр хөрөнгө санхүүгийн асуудал гацсан зүйл үгүй гэж бидэнд мэдээлсэн ч бодит байдал дээр компаниуд өөрсдийн хөрөнгөө барьцаанд тавин гүүрийн барилгын ажлыг үргэлжлүүлж байлаа. Иргэдийн “Замын ажил явагдахгүй байна” гэдэг ч ор үндэсгүй зүйл байсангүй. Одоогийн байдлаар 3.6 км замын ажил хийгдээгүй гэнэ. Харин гүүрийн ажил дуусч байгаа бөгөөд энэ сарын 17-нд хөдөлгөөнийг нь нээх аж.

Нэгхэн чиглэлийн автобустай тамаа цайж байна гэв

Манай сурвалжлах хэсэг компаниудын байр суурийг сонссоны дараа иргэдтэй уулзсан юм. Үйлдвэрчний эвлэлийн гудамжнаас Толгойтын эцэс хүртэлх замыг анх 1978 онд, Толгойтын эцэсээс Орбитын уулзвар хүртэлх замыг 1985 онд ашиглалтад оруусан түүхтэй. Эдүгээ Толгойтын оршин суугчид 38

ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATAK PLAY STORE TATAK APP STORE

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

жил уг замаар алхаж, ажил амьдралаа залгуулдаг аж. Хуучин муу замыг нь хуулж авснаас болж Толгойтын бага наран хэсэгт шороо тоос бужигнаж, тоосжилт үүсчээ. Замын хөдөлгөөнийг зохицуулах ч зүйл байхгүй. Хэн дуртай нь хүссэн газраараа зам хөндлөн гарч, хаанаас ч хамаагүй машин огцом гарч ирнэ. Сургуулийн багачууд эрүүл орчинд амьдарч, аюулгүй замаар хичээлдээ явж байна уу гэдэг эргэлзээтэй.

Мөн шинэ зам барихтай холбогдуулан Толгойтын автобусны чиглэлийг өөрчилсөн байна. Тухайлбал, өмнө Толгойтын автобус 21 дүгээр хорооллын замаар явдаг байсан бол Хилчин хотхоноор тойрч явдаг болжээ. Тиймээс бид Сутайн Буянт компанийн автобусны жолооч Д.Болдбаатар ярилцсан. Тэрбээр “Шинэ зам барина гээд автобусны явах замыг өөрчилсөн. Ийм замаар том оврын автобус явна гэдэг амаргүй. Хэцүү л дээ. Энхэл, донхол ихтэй, шороо тоос их босдог. Тойрч явдаг болсноос хойш хэдэн минутаар хоцрох асуудал гарах болсон. Бид өдөрт 6-7 удаа явах төлөвлөгөөтэй. Яах вэ төлөвлөгөөндөө хүрч ажиллаж байгаа. Автобус чинь цаг минутаар явдаг. Тэгэхээр цагаасаа хоцрох асуудал гарах болсон” гэв. Мөн удаан хөлтэй замын ажил нийтийн тээврийн чиглэлд хүртэл нөлөөлж байна. Тиймээс энэ ажлаа хурдан дуусгах хэрэгтэй гэдгийг тэрбээр хэлсэн. Бид түүнтэй ийнхүү ярилцсаны дараа оршин суугчидтай уулзаж, тэдний байр суурийг сонссон юм.

...Толгойтын зам 30 гаруй жил болж байгаа. Шүүрэн шанага шиг л байсан. Янзалж өгнө, сайхан болгоно гэсэн. Бид хүлээгээд л байгаа. Энэ талаар ярихаас ч уур хүрч байна. Нэг их том том юм ярьсан улсууд Land унаад давхиад л байдаг. Гэтэл бид нэг чиглэлийн автобусаа цаг орчим хүлээж, шахалдаж явж байна. Үүлээ үзэж, тамаа цайж байна шүү дээ, иргэд. Бодит байдлыг хэл гэвэл иймэрхүү. Тэгэхэд иргэддээ ганц зам бариад өгөхөд яах вэ дээ...



хөдөлгөөн маш их байдаг. Түүнээс болж тоосжилт ихээр үүссэн. Тэгээд л хүүхдүүд ханиад томуу хүрэх, харшилтай болох гэх мэтчилэн өвчлөл их нэмэгдсэн. Замын ажил явуулна гэсэн. Одоогоор гүүрний ажил явагдаж байна билээ. Энэ сарын 10-нд гүүр нээгдэнэ гэсэн үнэн эсэхийг мэдэхгүй. Зам барилгын ажилтай холбоотой бэрхшээлтэй зүйл олон бий. Тухайлбал, Толгойтын автобус тун цөөхөн явж байна. Буудал дээрээ ирдэггүй. Ирсэн ч цаг цагийн зайтай ирж байна. Явахгүй байгаа. Энэ маш хэцүү шүү дээ. Манай хороонд сургууль, цэцэрлэгт явдаг хүүхдүүд, төвийн төвд ажилладаг иргэд, оюутнууд олон. Бүгд ажлаасаа, хичээлээсээ хоцордог. Ялангуяа оюутнуудад хэцүү л дээ. Хичээлээ хоцордог. Хоцрохгүй байх гэхээр автобус нь явахгүй. Хоцроод очихоор багш нар хичээлдээ суулгахгүй, оноо хасах гэх мэтчилэн арга хэмжээ авдаг. Ер нь олон асуудал байгаа. Гүүрний ажлаа аль болох ажлаа хурдан хийх л хэрэгтэй. Замаа больё гэхэд гүүрээ дуусгачих. Тэгвэл бидний амьдралын цаг хугацаа нийтийн тээвэр хүлээж, ажлаа, хичээлээ алдахгүй болно.

А.Сувд: Нэгхэн чиглэлийн автобустай тамаа цайж байна

/Их нарангийн IV дүгээр хороо/

Гүүрний ажил зургадугаар сард эхэлсэн. одоо болтол дуусаагүй. Замыг нь ярих ч хэрэг

ХҮРТЭЛ ШИНЭ ЗАМ ДЭЭР ГИШГЭХГҮЙ НЬ...

Ч.Энхтөр: Энэ замыг ашиглалтад орохыг Толгойтынхон бүгд хүлээж байна

/Бага нарангийн III дугаар хорооны иргэн/

Энэ замыг ашиглалтад орохыг Толгойтынхон бүгд хүлээж байна. Удахгүй ашиглалтад орно л гэдэг. Тэгээд л ордоггүй. Аль дээр л орно гэж байсан. Одоо ордог бол орох хугацаа нь болсон. Асуухаар л санхүүжилт байхгүй гэдэг. Мөн замыг чинь шинэчилнэ, сайхан болгоно гээд автобусны чиглэлийг өөрчилчихсэн. Бид одоо доошоо гүүр рүү алхаж автоусанд сууж байгаа. 1-2 км алхаж хөл залгах унаатай болдог. Энгийн иргэд бид ямар машин такси барина гэх биш. Барьсан ч тоотой л барина шүү дээ. Байнга таксидах хэцүү. Хар л даа. Одоо ч хүмүүс алхаж л байна. Юу гэсэн үг вэ. Улс орон хөгжиж байна гэдэг. Гэтэл хотын захын хорооллын оршин суугчид нь л 1-2 км алхаж нийтийн тээврийн үйлчилгээг авч байна. Ийм ялгавартай хандаж болохгүй шүү дээ. Өөрөөр хэлбэл, хотоо ялгаварлаж хөгжүүлээд байна, тэр гишүүд чинь. Өдөр ч яах вэ явж болж л байна. Шөнө орой явахад хэцүү. Тэгээд автобус нь хэдэн минутын дотор ирэхгүй. Хүлээлгэж, хүлээлгэж ирнэ. Бараг цаг орчим автобус хүлээж буудал дээр зогсож байна, бид. Тэгэхээр төр засгийн хүмүүс сонсож байвал замын асуудлыг хурдан шийдэж өгөөч гэж хүсмээр байна. Энэ чинь дундаа ажил нь зогсоод их удсан. Яасан бэ гэхээр нам төр солигдоод санхүүжилт нь зогссон л гэсэн. Уг нь сонгууль эхлэхээс өмнө хамаг замыг ухаж хаячихаад долдугаар сард ажлаа эхэлсэн. Ядаж энэ хоёр гүүрээ ашиглалтад оруулчих хэрэгтэй. Тэгвэл бид гүүрээрээ шулуун яваад автобусандаа хурдан суучихна. Шийдэх асуудал олон байна.

Б.Даваахүү: Замын ажлаас болж автобусны

чиглэл өөрчилсөн нь бидэнд их хүнд тусч байна

/Бага нарангийн III дугаар хорооны иргэн/

Ингэсээр байтал өвөл болшоо. Өвөл барьсан зам ямар олигтой байв гэж. Ойлгомжтой. Ямар ч зохион байгуулалт байхгүй. Уг нь энгийнээр бодоход л гүүрээ нэг компани хийж байхад нөгөө компани нь хар замаа цутгалгүй хашлагаа тавиад явж болохоор байгаа юм. Гэтэл тийм зүйл байхгүй. Гүүр болгонд нэг компани очихсон. Тэгээд л санхүүжилт байхгүй гээд зогсоод л байна. Хэдэн ч жил зогсов. Сургуулийн хүүхдүүд явахад хэцүү. Гүүрний доод талын жалгаар дамжиж гарч ирдэг. Шөнө орой гэрэлтүүлэг байхгүй болохоор их хэцүү. Элдэв янзын дээрэм, хэрэг гарах өндөр магадлалтай. Ер нь гэмт хэрэг гарах нөхцөл нь бүрдсэн. 3.4 км замыг ашиглалтад оруулах гэж их удаж байна. Манай энэ орчмын зам шиг замтай газар байхгүй. Их олон жил болж байгаа. Одоо энд автобус ч ирэхээ больсон. Удаж байж нэг ирдэг. Тэгээд л автобусны буудал дээр автобус хүлээсэн хүмүүс. Би бүр цаашаа алхаж Их нарангийн автобусанд суудаг болсон. Ялангуяа цайны цагаар алга болчихдог. Очихоор хуучин эцэс дээрээ бүгд зогсож байдаг. Энэ замыг тавина гэж л автобусны чиглэлийг өөрчилсөн. Үр дүнд нь иргэд л хохирлоо. Хэлсэн амандаа хүрээд замаа цаг тухайд нь барьчихдаг бол сайхан л байна. Энэ янзаараа автобусны чиглэл хуучин хэвэндээ орохгүй болов уу.

Н.Сувдмаа: Ядаж гүүрний ажлаа хурдан дуусгачих

/Бага нарангийн III дугаар хорооны IX дүгээр хэсгийн ахлагч/

Манай хороо 2400 гаруй өрхтэй, 10 мянга гаруй хүн амтай. Энэ хэсэгт замын



байхгүй. Бүр яриад нэмэргүй шүү. Толгойтынхон энэ замыг ашиглалтад ороосой гэж их хүсч байгаа. Төрийн эрх мэдэлтэй хүмүүс шийдэж өгнө л гэдэг. Өнөөдрийг хүртэл шийдсэн зүйл алга. Гүүрнийх нь ажил санхүүжилт байхгүй гэж хэсэг зогссон. Яриад байвал олон асуудал бий. Толгойтын зам 30 гаруй жил болж байгаа. Шүүрэн шанага шиг л байсан. Янзалж өгнө, сайхан болгоно гэсэн. Бид хүлээгээд л байгаа. Энэ талаар ярихаас ч уур хүрч байна. Нэг их том том юм ярьсан улсууд Land унаад давхиад л байдаг. Гэтэл бид нэг чиглэлийн автобусаа цаг орчим хүлээж, шахалдаж явж байна. Үүлээ үзэж, тамаа цайж байна шүү дээ, иргэд. Бодит байдлыг хэл гэвэл иймэрхүү. Тэгэхэд иргэддээ ганц зам бариад өгөхөд яах вэ дээ.

О.Эрдэнэ-Оюун: Гүүр ашиглалтад орчихвол тойрох шаардлагагүй болно

Гүүрний ажил нь явагдаж байгаа. Харин хурдан дуусаасай гэж боддог. Энэ замыг барина гээд автобусны чиглэлийг өөрчилчихсэн юм. Тэрнээс болж өглөө хичээлд явахад хэцүү байдаг. Тойрч явдаг болохоор их цаг зарцуулдаг. Хичээлдээ очихын тулд бараг цаг гаран явж байна. Тэгэхээр их ядардаг. Ялангуяа орой эрт тарсан үед, Заримдаа эрт хичээл тарсан үед ч гайгүй. Одоо өвөл болчихвол эрт харанхуй болно. Тэгвэл яана даа л гэж бодож байна. Хичээл орой тарвал явахад хэцүү шүү дээ. Замаас гадна нэг хэцүү асуудал манай хороонд бий. Гэрэлтүүлэг огт байдаггүй. Гэрэлгүй болохоор орой явахад хэцүү л дээ. Уг нь 21 дүгээр хорооллод буусан тохиолдолд Чингис СООСЭ сургуулийн урдас 1000 төгрөгийн унаа явдаг. Тэр нь суугаад ирж болно. Гэхдээ үргэлж 1000 төгрөгийн машинд сууна гэдэг хэцүү. Би оюутан болохоор автобусны мөнгөнөөс гадна хоолны мөнгө, элдэв ном авах хэрэг ч гардаг. Гүүр ашиглалтад орчихвол болно.

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

Хоёр ертөнцийн зааг



Б.ДАВАА

Байгаль ертөнц, хүн төрөлхтөн хоёулаа гайхалтай уран бүтээлчид. Тэд хамтарч чадсанаар гайхалтай урлагийн бүтээлүүд төрөн гардагийн нэгээхэн жишээ нь энэ. Техник технологи хөгжихийн хирээр ямар ч муу зургийг фотошопоор янзлаад л төгс болгочихдог болсон. Гэхдээ энэ удаа ямар ч фото шоггүйгээр авсан гайхалтай гэрэл зургийн цомгоос дээрх бүтээлийг сонгон уншигчиддаа сонирхуулахаар бэлдлээ. Зургийг байгаль, барилга архитектурын чиглэлээр дагнан уран бүтээл туурвидаг америк гэрэл зурагчин Калтен Долматч Нью Йорк хотноо авчээ.

Машиныуд зөрөлдөн өнгөрөх авто зам амьд байгаль урган төлжих үзэмж төгөлдөр цэцэрлэгт хүрээлэн болон барилга байгууламж сүндэрлэх их хотын чимээг зааглан орших ажээ.

Бидэнд тохиолдсон



Күндхэн хөгтэй
Явдлууд

Misha Masha

Нөхөр шөнө хөдөөнөөс ирнэ гэж хэлсэн байсан юм. Тэгээд шөнө сайхан унтаж байтал хаалга нүдлээ. Би ч халууцаад унтлагийн хувцас, хөхөвчөө тайлж шидчихээд охиноо хөхүүлж байсан тэр чигтээ унтчихсан байв. Шийдчихсэн гар дотуур хувцастайгаа үүд рүү дөхөж очоод хаалгаа нээтэл гар чийдэнгийн гэрэл нүүрэн дээр тусаад царай нь харагддаггүй. Орооч ханна зогсоод байх юм гэтэл манай нөхрийн найзууд “Болдоо байна уу” гэдэг юм даа. Ёоо, ичиж үхэх нь.

ХОЛЛИВУДЫН СОНИН САЙХАН

Женнифер Гарнер: БРЭД ПИТТЭЙ болзож байгаа

Холливудын сайхан бүсгүйчүүдийн нэг жүжигчин Женнифер Гарнер Брэд Питтэй болзож байгаа хэмээжээ. Тэрбээр нөхөр Бен Аффлекаас салж, арван жилийн хамтын амьдралдаа цэг тавьж буйгаа өнгөрсөн жилийн зургадугаар сард олон нийтэд зарлаж байсан удаатай. Хосууд гурван хүүтэй байсан юм. Тэгвэл жүжигчин бүсгүйг Лос Анжелес хотод найзтайгаа гадуур алхаж явахад нь папарацчид бүчин авч, хувийн амьдралынх нь тухай сонирхжээ. Харин бүсгүй тайвнаар “Брэд Питтэй болзож байгаа” хэмээн хошигносон гэнэ. Улмаар зурагчин “Брэд Питтэй үерхэж байгаа юм уу” гэж асуухад “Тиймээ гайхалтай биш байна уу” гэж инээмсэглэн хэлжээ. Брэд Питт өнгөрсөн сард эхнэр Анжелена Жолитоос салж буйгаа мэдэгдсэн бөгөөд өөрийн болон өргөмөл зургаан хүүхдээ хэн өсгөх нь олны анхаарлыг татаж байгаа юм.



Ким Кардашьян АЛМАЗАН БӨГЖӨӨ алдав

АНУ-ын реалити шоуны од Ким Кардашьян халдлагад өртөж, дээрэмдүүлсэн хэрэг энэ сарын 3-нд Парист гарсан билээ. “Од” бүсгүй тус хотод загварын долоо хоногт оролцохоор хүрэлцэн ирээд байжээ. Гэсэн ч түүний байрлаж байсан тансаг зэрэглэлийн орон сууц руу цагдаа хувцас өмсөн зүсээ хувилгасан хоёр буутай этгээд халдаж, Кимийн гар хөлийг хүлж, буу тулган сүрдүүлж, үнэт эдлэлийг нь дээрэмдэж явсан тухай зарим сайтууд мэдээлсэн юм. Гэхдээ өчигдрийн байдлаар үнэт эдлэл хэдий хэрийн мөнгөөр үнэлэгдэх нь тодорхойгүй байсан. Тэгвэл хохирлын нийт хэмжээ есөн сая еврод хүрсэн тухай франц пресс мэдээлэв. Мөн хэрэгт таван хүн оролцсон гэдгийг цагдаагийн газраас нотоллоо. Тэдний хоёр нь Кимийн байр руу халдаж, тэр үед унтлагын өрөөндөө байсан бүсгүйн гар хөлийг хүлэн угаалгын өрөөнд нь түгжсэн гэнэ. Одоогоор бүсгүй Нью Йорк дахь гэртээ харсан бөгөөд ойрын эх сурвалж нь цочиролд орсны улмаас салганан чичирч байсан тухай ярьжээ. Гэхдээ азаар гэмтэж бэртээгүй аж. Хулгайд алдсан нийтдээ есөн сая еврогоор үнэлэгдэх үнэт эдлэлд дөрвөн сая еврогийн үнэтэй нөхрийнх нь бэлэглэсэн алмаазан бөгж нь хүртэл байжээ. Мөн хоёр гар утсаа дээрэмдүүлсэн байна.

ДУУЛГАХ СОНИН

“Жаргаагүй нар” ДРАМЫН ТАЙЗНАА АМИЛНА

Д.Нацагдоржийн нэрэмжит, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Улсын драмын эрдмийн театрын 85 жилийн ойн баяр ирэх арваннэгдүгээр сард тохиож байна. Тиймээс тус театрын уран бүтээлчид Д.Нацагдоржийн мэндэлсний 110 жилийн ой, УДЭТ-ын 85 жилийн ойд зориулан их зохиолч Д.Нацагдоржийн амьдралаас сэдэвлэсэн “Жаргаагүй нар” түүхэн жүжгийг ирэх сарын 4-нд тайзнаа тоглохоор болжээ. “Жаргаагүй нар” хэмээх шинэ уран бүтээлийн зохиолчоор Соёлын гавьяат зүтгэлтэн Ш.Гүрбазар, найруулагчаар нь Соёлын тэргүүний ажилтан Ч.Түвшин нар ажиллаж байна.

МОНГОЛ ХҮҮХЭЛДЭЙН КИНО ҮЗЭГЧДИЙН ХҮРТЭЭЛ БОЛНО

Монгол уран бүтээлчдийн “Шидэт хуудас” нэртэй бүрэн хэмжээний зурмал 2D хүүхэлдэйн кино энэ оны сүүлээр үзэгчдийн хүртээл болох гэж байна. “Chuka's studio” -гийн хамт олны туурвиж буй энэхүү бүтээлд эвтэй дөрвөн амьтан, 12 жил, гурван настай гуанан баатар, эрхий мэргэн, болдоггүй бор өвгөн зэрэг монгол үлгэрийн баатруудыг оруулж байгаа тул илүү сонирхолтой болно гэж уран бүтээлчид нь үзжээ. Энэхүү хүүхэлдэйн киноны ерөнхий найруулагчаар компьютер график дизайны мэргэжилтэй, одоогоор КУДС-д кино найруулагчийн ангид суралцаж байгаа уран бүтээлч ажиллаж байгаа бол зургийг залуу зураачид зурж байгаа гэнэ. Тэд тус бүтээлд монгол ахуй соёл, монгол дүрийг тусгахыг хичээсэн бөгөөд дараа дараагийн бүтээлүүддээ ч ийм өнгө аясыг шингээхийг зорьж буй талаараа ярьсан байна. “Шидэт хуудас” хүүхэлдэйн кинонд нэг ангийн хоорондоо таарамж муутай гурван хүүхдэд тохиолдсон адал явдлын тухай өгүүлдэг байна. Гол дүрийн баатрууд санаандгүй байдлаар үлгэрийн ертөнцөд орох бөгөөд харих замаа хамтдаа хайх явцаа сайн найзууд болж, эвлэлдэн нэгдэж, үлгэрийн ертөнцийг аварч байгаагаар үйл явдал үргэлжлэх ажээ.

ТЭНГИС
BIBLIOTHECA



“Deepwater Horizon” нь найруулагч Peter Berg-н найруулсан, Deepwater Horizon хэмээх өрмийн цамхгийн сүйрлийн бодит түүхээс сэдэвлэсэн бүтээл юм.



Риогийн олимпис мөнгөн медаль хүртэж эх орныхоо нэрийг дэлхийн тавцанд гаргасан жүдоч Д.Сумьяагийн амьдралаас сэдэвлэн бүтээв.




Жэкоб хүүд нэгэн захиа ирсний дагуу нууцлаг арал дээр очно. Тэнд төрөл бүрийн өвөрмөц чадвартай хүүхдүүд амьдардаг Хатагтай Перегриний өвөрмөц хүүхдийн ордон байлаа.

УДАХГҮЙ ТЭНГИСИЙН ДЭЛГЭЦНЭЭ



Гарах хугацаа 2016.10.07



Гарах хугацаа 2016.10.13



Гарах хугацаа 2016.10.14



Гарах хугацаа 2016.10.20



Гарах хугацаа 2016.10.28